



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

БАЙГАЛЬ ОРЧИН - ЭДИЙН ЗАСГИЙН ДАНСНЫ  
СИСТЕМ

ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН  
ДАНС-2022

Улаанбаатар хот  
2023 он





ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНС - 2022

Улаанбаатар хот  
2023 он

#### ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Ц.Тэгшжаргал          Үндэсний тооцооны хэлтсийн дарга

#### ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

Д.Энхзаяа          Үндэсний тооцооны хэлтсийн ахлах статистикч

И-мэйл: [enkhzaya@nso.mn](mailto:enkhzaya@nso.mn)

Утас: 51-261502

#### ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44

Засгийн газрын III байр

Утас: 1900-1212

Цахим хуудас : [www.nso.mn](http://www.nso.mn), [www.1212.mn](http://www.1212.mn)

И-мэйл: [information@nso.mn](mailto:information@nso.mn)

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	5
НЭГ. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ.....	7
1.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ НӨӨЦ БОЛОН АШИГЛАЛТ.....	7
1.2. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААРХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ .....	8
1.3. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ .....	9
ХОЁР. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ҮР ДҮН.....	10
2.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ НИЙТ НӨӨЦ.....	10
2.1.1. ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ .....	10
2.1.2. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ .....	12
2.1.3. ХОГ ХАЯГДАЛ, эдийн засгийн салбараар .....	13
2.1.4. ДАХИН АШИГЛАСАН, БОЛОВСРУУЛСАН ХОГ ХАЯГДАЛ .....	14
2.2. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ НИЙТ АШИГЛАЛТ .....	14
ГУРАВ. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	15
3.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНААС ТООЦСОН ТХЗ-ЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	15
ДҮГНЭЛТ .....	16
АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....	18

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОЭЗДС	Байгаль орчин-эдийн засгийн дансны систем
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ЗГ	Засгийн газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТЕГ	Татварын ерөнхий газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хатуу хог хаягдлын дансны нөөцийн хүснэгтийн загвар.....	7
Хүснэгт 2. Хатуу хог хаягдлын дансны ашиглалтын хүснэгтийн загвар.....	7
Хүснэгт 3. Хатуу хог хаягдлын дансны нийт нөөц.....	10
Хүснэгт 4. Энгийн хог хаягдал, төрлөөр.....	11
Хүснэгт 5. Аюултай хог хаягдал, эх үүсвэрээр.....	12
Хүснэгт 6. ААНБ-д бий болсон хог хаягдал, салбараар.....	13
Хүснэгт 7. Дахин ашигласан, боловсруулсан хог хаягдал, төрлөөр.....	14
Хүснэгт 8. Хатуу хог хаягдлын дансны нийт ашиглалт.....	14
Хүснэгт 9. Хатуу хог хаягдлын данснаас тооцсон ТХЗ-ын үзүүлэлтүүд.....	15

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Энгийн хог хаягдлын бүтэц, төрөл, дүнд эзлэх хувиар.....	11
Зураг 2. Аюултай хог хаягдлын бүтэц, эх үүсвэр, дүнд эзлэх хувиар.....	12

## ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Хатуу хог хаягдлын дансны нөөцийн хүснэгт, 2021 он	
Хавсралт 2. Хатуу хог хаягдлын дансны ашиглалтын хүснэгт, 2021 он	
Хавсралт 3. Хатуу хог хаягдлын дансны нөөцийн хүснэгт, 2022 он	
Хавсралт 4. Хатуу хог хаягдлын дансны ашиглалтын хүснэгт, 2022 он	

## ОРШИЛ

Хог хаягдал нь манай улсын төдийгүй дэлхий нийтийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Хүний амьдрах орчин, эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдал сөрөг нөлөө үзүүлдэг. Түүнчлэн байгалийн нөөц баялгийг хомсдуулж, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж байна.

Хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилтийн өсөлттэй холбоотойгоор хог хаягдлын хэмжээ жил тутамд эрчимтэй нэмэгдэж байна. Дэлхийн банкнаас эрхлэн гаргасан "What a waste 2.0: A Global Snapshot of Solid Waste Management to 2050" тайланд дэлхийд жилд 2.0 тэрбум тонн хог хаягдал бий болдог бөгөөд 2050 он гэхэд 3.4 тэрбум тонн болж өснө гэж дурдсан байна.

Хог хаягдлын дансны зорилго нь хог хаягдлын эх үүсвэр, төрөл, байгаль орчинд хаягдаж байгаа хэмжээ зэрэг мэдээллийг аргачлалын дагуу нэгтгэн харуулах, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, судлаачдыг бодитой найдвартай мэдээллээр хангахад оршино.

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан ба Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлого, Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд хог хаягдлын менежментийг сайжруулж хог хаягдлыг бууруулах, хүн амын амьдрах тав тухтай эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр зорилтуудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал, "Алсын хараа-2050"-д хог хаягдлын дахин боловсруулах хэмжээг 2025 онд 30 хувь, 2030 онд 40 хувьд хүргэх, Ногоон хөгжлийн бодлогод байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг 2030 онд 40 хувь бууруулах зорилтыг тус тус дэвшүүлсэн байна.

Хог хаягдлын менежментийг сайжруулах, төлөвлөлт хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, үнэлэхэд хог хаягдлын нарийвчилсан дэлгэрэнгүй тоо мэдээллийн хэрэгцээ шаардлагатай байна.

Энэхүү танилцуулгын эхний хэсэгт хатуу хог хаягдлын дансны талаарх ерөнхий ойлголт, 2 дугаар хэсэгт Монгол Улсын хатуу хог хаягдлын дансны 2022 оны гүйцэтгэлийн үр дүн, 3 дугаар хэсэгт данснаас тооцсон тогтвортой хөгжлийн зорилтын холбогдох үзүүлэлтийн дүнг танилцуулсан. Харин дүгнэлт хэсэгт хатуу хог хаягдлын дансны тооцооны явцад гарсан хүндрэл, цаашид анхаарах асуудлыг тодорхойлсон.

## НЭГ. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

### 1.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ НӨӨЦ БОЛОН АШИГЛАЛТ

Монгол Улс нь байгалийн нөөцөд тулгуурласан эдийн засагтай орны хувьд байгаль орчны статистик мэдээллийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж, тэдгээрийг өргөжүүлэн хөгжүүлэх, тогтмолжуулах шаардлага зайлшгүй тулгарч байна.

Хатуу хог хаягдлын талаарх статистикийн мэдээлэл нь олон улсын болон үндэсний хог хаягдлын менежментийн бодлогын хүрээг тодорхойлох, хэрэгжилтийг үнэлэхэд маш чухал үүрэгтэй байдаг. Хатуу хог хаягдлын данс нь БОЭЗДС-ийн биет урсгалын дансны нэг юм. Биет урсгалын данс нь байгаль орчноос эдийн засагт орох урсгал, эдийн засаг доторх урсгал, эдийн засгаас байгаль орчин руу чиглэх урсгал буюу үлдэгдлийн урсгалыг бүртгэнэ. Хатуу хог хаягдал нь үлдэгдлийн урсгалд хамаарна. Үлдэгдэл нь байгаль орчинд шууд хаягдах, орхигдох, эсвэл эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд дахин хэрэглэгдэж, дахин боловсруулагдана. Хатуу хог хаягдлын данс нь эдийн засгийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон буюу үйлдвэрлэгдсэн хатуу хог хаягдал, гадаад орноос орж ирсэн хог хаягдлын импорт, хог хаягдал цуглуулах, ариутгах, боловсруулах үйл ажиллагааны үр дүнд цуглууллагдсан хатуу хог хаягдал, гадаад улсад гаргаж байгаа хатуу хог хаягдлын экспорт болон байгаль орчинд шууд хаягдаж байгаа хатуу хог хаягдлын урсгалыг харуулна.

Хатуу хог хаягдлын биет урсгалын данс нь нөөцийн хүснэгт, ашиглалтын хүснэгт гэсэн үндсэн 2 хүснэгтээс бүрдэнэ. Хатуу хог хаягдлын дансны нөөцийн хүснэгт нь эдийн засгийн салбарууд болон өрхийн үйлдвэрлэл хэрэглээний явцад үүссэн хог хаягдал, дахин ашиглах, дахин боловсруулах зорилгоор цуглуулсан хог хаягдал, импортоор оруулсан хог хаягдлыг бүртгэнэ.

### ХҮСНЭГТ 1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ НӨӨЦИЙН ХҮСНЭГТИЙН ЗАГВАР

Хатуу хог хаягдлын эх үүсвэр - Дотоод						Гадаад эдийн засаг	НИЙТ НӨӨЦ
Эдийн засгийн салбарууд						Хатуу хог хаягдлын импорт	
ХАА	Уул уурхай	Боловсруулах	Үйлчилгээ	Өрх	Дахин боловсруулах, дахин ашиглах		

Хатуу хог хаягдлын үлдэгдэл, төрлөөр

Хатуу хог хаягдлын ашиглалтын хүснэгт нь хог хаягдал цуглуулах, цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан хог хаягдал хэрхэн зайлуулагдсан, дахин ашиглах, боловсруулах хог хаягдал нь үйлдвэрлэлийн бусад салбарт ашиглагдсан хэмжээ, экспортлосон болон байгальд шууд хаягдаж байгаа хог хаягдлыг харуулна.

### ХҮСНЭГТ 2. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТИЙН ЗАГВАР

Завсрын хэрэглээ; үлдэгдлийн цуглуулалт				Гадаад эдийн засаг	Байгаль орчинд орох урсгал	НИЙТ АШИГЛАЛТ
Хог хаягдал цуглуулах, цэвэрлэх, зайлуулах			Бусад салбарын завсрын хэрэглээнд	Хатуу хог хаягдлын экспорт		
Ландфилл /газарт булшлах/	Шатаах	Бусад				

Хатуу хог хаягдлын цуглуулалт, зайлуулалт, төрлөөр

Хатуу хог хаягдлын дансны мэдээллийн үндсэн эх үүсвэр нь БОАЖЯ-ны захиргааны мэдээлэл буюу “Энгийн хатуу хог хаягдлын жилийн мэдээ БОХ 6.1”, “Аюултай хог хаягдлын жилийн мэдээ БОХ 6.2”, “Хог хаягдлын дахин ашиглалт, боловсруулалтын жилийн мэдээ БОХ 6.3” болон холбогдох судалгааны мэдээлэл байна.



Хатуу хог хаягдлын дансны үзүүлэлтийн хэмжих нэгж нь тонн байна.

Хатуу хог хаягдлын дансны мэдээлэлд үндэслэн Тогтвортой хөгжлийн зорилго, урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан үзүүлэлт, ногоон хөгжлийн үзүүлэлтүүдийг тооцохоос гадна хатуу хог хаягдлын менежмент болон бусад төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг үнэлнэ.

## 1.2. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААРХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хог хаягдал үүсгэгч болон бусад оролцогч талуудын хог хаягдлын зохицуулалттай холбогдох эрх, үүргийг тодорхойлсон суурь эрх зүйн баримт бичиг нь 2017 онд шинэчлэн батлагдсан Хог хаягдлын тухай хууль юм.

Энэ хуулиар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулж байна.

Түүнчлэн хог хаягдлын менежменттэй холбоотой дараах үндсэн журмуудыг мөрдөж байна. Үүнд:

- Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам  
/Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.02.20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолын хавсралт/
- Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага  
/Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018.11.17-ны өдрийн А-443 дугаар тушаалын хавсралт/
- Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар  
/Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018.11.19-ний өдрийн А-445 дугаар тушаалын хавсралт/
- Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам  
/Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018.11.12-ны өдрийн А-428 дугаар тушаалын хавсралт/
- Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт  
/Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018.11.13-ны өдрийн А-429/257 дугаар тушаалын хавсралт/
- Байгаль орчинд ээлтэй арга, технологи нэвтрүүлсэн хувь хүн, аж ахуйн нэгжийг урамшуулах журам  
/Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолын хавсралт/

- Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай  
/Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоол/

### 1.3. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

#### Хог хаягдал:

Өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материалыг хэлнэ.

#### Хог хаягдлын үлдэгдлийн урсгал:

Хаягдлыг ямар нэгэн төлбөргүйгээр хүлээн авч байгаа урсгалыг хэлнэ.

#### Хог хаягдлын бүтээгдэхүүний урсгал:

Хог хаягдлыг ямар нэгэн төлбөртэйгээр хүлээн авч байвал, мөн хаягдал материал дахин ашиглагдаж байвал түүнийг хог хаягдлын бүтээгдэхүүний урсгал гэнэ.

#### Хог хаягдал цуглуулах:

Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор эх үүсвэрээс төвлөрүүлэхийг хэлнэ.

#### Хог хаягдал ангилах:

Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор төрөлжүүлэн ялгахыг хэлнэ.

#### Ландфилл:

Хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламжийг хэлнэ.

#### Хог хаягдлыг устгах:

Хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор ландфиллд булшлах, биологийн болон хими, физикийн аргаар боловсруулах, шатаах, халдваргүйжүүлэх, савлаж хадгалахыг хэлнэ.

#### Хог хаягдлыг булшлах:

Хог хаягдлыг газарт булж хадгалахыг хэлнэ.

#### Хог хаягдлыг шатаах:

Хог хаягдлыг зориулалтын байгууламжид шатааж задлахыг хэлнэ.

#### Хог хаягдал дахин боловсруулах:

Хог хаягдлаас шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг хэлнэ.

#### Хог хаягдал дахин ашиглах:

Ашиглагдаж байсан зорилгоор нь хог хаягдлыг эргүүлэн хэрэглээнд оруулахыг хэлнэ.

#### Дахивар нөөц:

Дахин ашиглагдах, дахин боловсруулах, сэргээн ашиглагдах хог хаягдлыг хэлнэ.

#### Ахуйн хог хаягдал:

Айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.

#### Аюултай хог хаягдал үүсгэгч:

Үйл ажиллагаа болон үйлдвэрлэлээс нь аюултай хог хаягдал үүсдэг аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ.

#### Аюултай хог хаягдал тээвэрлэгч:

Аюултай хог хаягдлыг үүсгэгч болон өмчлөгчөөс тээврийн хэрэгслээр хүлээн авагчид хүргэх үйл ажиллагаа эрхлэгчийг хэлнэ.

#### Хог хаягдлын норматив:

Нэгж үйлдвэрлэл, үйлчилгээ, иргэнээс үүсэх хог хаягдлын тогтоосон хэмжээг хэлнэ.

## ХОЁР. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ҮР ДҮН

Хатуу хог хаягдлын дансыг байгуулах аргачлалын дагуу хатуу хог хаягдлын дансыг байгуулж, үр дүнг танилцуулж байна.

### 2.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ НИЙТ НӨӨЦ

Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар хог хаягдлын төвлөрсөн 396 цэг байгаа бөгөөд эдгээр нь нийтдээ 3811.6 га талбайг эзэлж байна. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн тоог 2021 онтой харьцуулахад 9 цэг буюу 2.3 хувь, төвлөрсөн цэгийн талбай 104.7 га талбай буюу 2.8 хувиар тус тус өссөн байна.

Хог хаягдлын тухай хуульд хог хаягдлын үйлчлэх хүрээг энгийн хатуу хог хаягдал, аюултай хог хаягдал гэж тодорхойлсон.

Хатуу хог хаягдлын дансыг байгуулахдаа Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 дүгээр тушаалаар зөвшөөрснөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/527 дугаар тушаалаар баталсан “Энгийн хатуу хог хаягдлын жилийн мэдээ (БОХ 6.1)”, “Аюултай хог хаягдлын жилийн мэдээ (БОХ 6.2)”, “Хог хаягдлын дахин ашиглалт, боловсруулалтын жилийн мэдээ (БОХ 6.3)” маягтаар цуглуулсан мэдээллийг ашигласан.

Хатуу хог хаягдлын дансны нийт нөөц нь цуглуулж, тээвэрлэж хогийн цэгт хаясан энгийн болон аюултай хог хаягдал, дахин ашиглах, боловсруулах зорилгоор цуглуулсан хог хаягдал болон хог хаягдлын импортоос бүрдэнэ.

Хатуу хог хаягдлын дансны нийт нөөц 2021 онд 2814.2 мянган тонн байсан бол 2022 онд 2858.7 мянган тонн болж, 2021 онтой харьцуулахад 44.5 мянган тонноор буюу 1.6 хувиар өссөн байна. Хог хаягдлын дансны нийт нөөцийн бүтцийг 2022 оны байдлаар авч үзвэл, ААНБ-ын хог хаягдал 42.0 хувь, өрхийн хог хаягдал 55.3 хувь, дахин ашиглаж, боловсруулахаар цуглуулсан хог хаягдал 2.6 хувь, импортоор оруулж ирсэн хог хаягдал 0.1 хувийг тус тус эзэлж байна.

### ХҮСНЭГТ 3. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ НИЙТ НӨӨЦ, мянган тонноор

				Хог хаягдлын импорт	НИЙТ НӨӨЦ
	ААНБ-д бий болсон	Өрхөд бий болсон	Дахин ашиглах, боловсруулахаар цуглуулсан		
2019	1 317.0	1 612.0	250.6	1.9	<b>3 181.5</b>
2020	1 318.3	1 384.5	272.9	1.6	<b>2 977.3</b>
2021	1 104.7	1 520.8	186.8	1.9	<b>2 814.2</b>
2022	1 202.1	1 580.3	73.4	2.9	<b>2 858.7</b>

Энгийн хог хаягдлын тоо мэдээллийг салбаруудад хуваарилахын тулд ТЕГ-ын татварын баазаас авсан хог хаягдлын хураамжийн салбарын бүтцийг ашигласан. Харин аюултай хог хаягдлын мэдээлэл нь хог хаягдлыг үүсгэгч салбаруудаар гардаг.

#### 2.1.1. ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ

Аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг энгийн хог хаягдал гэж үздэг. Энгийн хог хаягдлыг ахуйн хог хаягдал ч гэж нэрлэх явдал байдаг. Манай улсад энгийн хог хаягдлын бүтцийг судлах чиглэлээр хэд хэдэн судалгаа хийгдсэн. Тухайлбал, Япон улсын Жайка байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газраас Улаанбаатар хотын хог хаягдлын бүтцийн судалгааг 2007 онд, “Хог хаягдал ба уур амьсгал” төслийн хүрээнд Азийн сангаас Улаанбаатар хотын ахуйн хог

хаягдлын бүтцийн судалгааг 2019 онд хийсэн байна. Эдгээр судалгаагаар гэр хороолол болон орон сууцанд амьдардаг айл өрхийн хог хаягдлын бүтцийг тодорхой тооны өрхийг хамруулан судалсан байна.

Европын холбооны санхүүжилттэй Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд хог хаягдлын менежментийн тогтолцоог тодорхойлох зорилгоор Эко сум (Булган аймгийн Хишиг-Өндөр сум)-ын хог хаягдлын суурь судалгааг 2020 оны 10 дугаар сараас 2021 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд зохион явуулсан байна.

Хатуу хог хаягдлын дансыг байгуулахдаа энгийн хатуу хог хаягдлын жилийн мэдээ (БОХ 6.1) маягтаар цуглуулсан мэдээллийг ашиглав. Уг маягтаар цуглуулсан мэдээллийг хог хаягдлын төрлөөр гэр хорооллоос, орон сууцнаас, зам талбайгаас, аж ахуйн нэгж, байгууллагаас, бусад газраас гэсэн ангиллаар нэгтгэдэг.

Хатуу хог хаягдлын биет урсгалын дансанд хог хаягдлыг төрлөөр, эдийн засгийн салбар, өрхөөр салгаж харуулдаг тул гэр хороолол болон өрхөөс цуглуулж тээвэрлэсэн хог хаягдлыг өрхөд, ААНБ, зам талбай, бусад газраас цуглуулсан хог хаягдлыг эдийн засгийн салбаруудад хамруулж авч үзсэн.

#### ХҮСНЭГТ 4. ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ, хог хаягдлын төрөл, мянган тонноор

Хог хаягдлын төрөл	2021			2022		
	Нийт	ААНБ	Өрх	Нийт	ААНБ	Өрх
<b>Нийт</b>	<b>2 402.5</b>	<b>881.7</b>	<b>1 520.8</b>	<b>2 496.5</b>	<b>916.2</b>	<b>1 580.3</b>
Цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал	186.0	105.4	80.6	159.1	75.3	83.8
Шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал	211.2	65.2	146.0	199.1	47.4	151.7
Хаягдал төмөр	44.4	29.2	15.2	60.9	45.1	15.8
Хуванцар бүтээгдэхүүний хаягдал	183.4	57.2	126.2	192.7	61.5	131.2
Барилгын хог хаягдал	71.7	71.7	-	101.2	101.2	-
Хүнсний бүтээгдэхүүний хаягдал	313.7	74.9	238.8	322.5	74.4	248.1
Цахилгаан барааны хаягдал	28.9	25.8	3.0	35.4	32.2	3.2
Автомашинны эд анги	25.9	25.9	-	70.4	70.4	-
Бусад хог хаягдал	1 337.2	426.3	910.9	1 355.3	408.7	946.6


Улсын хэмжээнд цуглуулж, тээвэрлэсэн энгийн хатуу хог хаягдлын хэмжээ 2021 онд 2402.5 мянган тонн байсан бол 2022 онд 2496.5 мянган тонн болж, 3.9 хувиар нэмэгдсэн байна.

Энгийн хатуу хог хаягдлын 63.3 хувийг өрхийн хог хаягдал, 36.7 хувийг ААНБ, зам талбай, бусад газраас цуглуулсан хог хаягдал эзэлж байна.

ААНБ, гудамж талбай, бусад газраас цуглуулсан хог хаягдлын мэдээллийг эдийн засгийн салбаруудад хуваарилахдаа ТЕГ-ын татварын мэдээллийн баазын хог хаягдлын хураамжийн дүнд үндэслэсэн. Салбар бүрийн хувьд хог хаягдлыг төрлөөр задлахдаа маягтаар цуглуулсан мэдээллийн бүтцийг ашиглан тооцсон.

Харин өрхийн хог хаягдлыг төрлөөр задлахдаа “Хог хаягдал ба уур амьсгал” төслийн хүрээнд 2019 онд явуулсан Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын бүтцийн судалгааны үр дүнг ашигласан.

ЗУРАГ 1. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН БҮТЭЦ, хог хаягдлын төрөл, дүнд эзлэх хувиар, 2022 он



Энгийн хог хаягдлын 2022 оны бүтцийг авч үзвэл хүнсний бүтээгдэхүүний хаягдал 12.9 хувь, шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал 8.0 хувь, хуванцар бүтээгдэхүүний хаягдал 7.7 хувь, цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал 6.4 хувь, барилгын хог хаягдал 4.1 хувь, автомашины эд ангийн хаягдал 2.8 хувь, хаягдал төмөр 2.4 хувь, цахилгаан барааны хаягдал 1.4 хувийг эзэлж байгаа бол бусад хог хаягдал 54.3 хувийг эзэлж байна.

### 2.1.2. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

Хүн, амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг аюултай хог хаягдал гэж үздэг. Аюултай хог хаягдлыг үйлдвэр, эрүүл мэндийн байгууламж, лаборатори, барилга, нураалт, лаг, хөдөө аж ахуй зэрэг салбар үүсгэдэг.


Манай улсад үйлдвэрлэлийн хог хаягдлын талаар хийсэн судалгаа хомс байна. Энэ дансанд аюултай хог хаягдлын жилийн мэдээ (БОХ 6.2)-г ашиглалаа.

Нийт цуглуулсан аюултай хог хаягдлын хэмжээ 2021 онд 223.0 мянган тонн байсан бол 2022 онд 285.9 мянган тонн болж 28.2 хувиар өссөн байна. Аюултай хог хаягдлын дийлэнх нь цахилгаан, дулаан үйлдвэрлэл болон уул уурхайн үйл ажиллагаанаас бий болжээ.

### ХҮСНЭГТ 5. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ, эх үүсвэр, мянган тонноор

Хог хаягдал, эх үүсвэрээр	2019	2020	2021	2022
<b>Нийт</b>	<b>316.4</b>	<b>458.8</b>	<b>223.0</b>	<b>285.9</b>
Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал	35.7	274.4	5.5	12.5
Боловсрол, шинжлэх ухааны байгууллагын хог хаягдал	1.9	0.0	0.1	0.0
Цахилгаан станц, дулааны үйлдвэрлэлийн хог хаягдал	101.8	101.3	124.6	185.9
Уул уурхайн үйл ажиллагааны хог хаягдал	125.8	77.6	90.1	85.6
Химийн бодисын үйлдвэрлэлийн хог хаягдал	2.0	0.1	0.0	0.0
Хог хаягдал боловсруулах үйлдвэрлэлийн хог хаягдал	0.0	0.2	0.3	0.0
Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн хог хаягдал	2.5	0.2	0.0	0.0
Ахуйн хэрэглээний хог хаягдал	34.8	3.2	1.1	1.1
Арьс шир, үслэг, ноос ноолуур, ээрмэлийн үйлдвэрлэлийн хог хаягдал	4.6	0.2	0.3	0.3
Бусад хог хаягдал	7.4	1.6	0.9	0.4

ЗУРАГ 2. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН БҮТЭЦ, эх үүсвэр, дүнд эзлэх хувиар



Аюултай хог хаягдлын бүтцийг 2019-2022 оноор авч үзвэл 2020 онд огцом өөрчлөлт гарсан ба энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эмнэлгийн аюултай хог хаягдал 2020 онд огцом нэмэгдсэн бол уул уурхайн аюултай хог хаягдал КОВИД-19 цар тахлын үед хэрэгжүүлсэн хатуу хөл хорионы арга хэмжээтэй холбоотойгоор буурсан байна.

### 2.1.3. ХОГ ХАЯГДАЛ, эдийн засгийн салбараар

Хатуу хог хаягдлын дансны нэг гол зорилго нь хог хаягдлыг эдийн засгийн салбаруудаар харуулахад оршино.

Хатуу хог хаягдлын дансны нийт нөөцийн 2022 оны дүнгээс харахад энгийн болон аюултай хог хаягдлын бүтэц салбаруудад харилцан адилгүй байна.

Энгийн хог хаягдлын хувьд барилга, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, дулаан, усан хангамжийн салбар өндөр хувь эзэлж байна. Харин аюултай хог хаягдлын хувьд цахилгаан, дулаан, усан хангамж, уул уурхай, олборлолтын салбар хамгийн өндөр хувийн жин эзэлж байна.

### ХҮСНЭГТ 6. ААНБ-Д БИЙ БОЛСОН ХОГ ХАЯГДАЛ, эдийн засгийн салбар, мянган тонноор

Салбар	2021			2022		
	Нийт	Үүнээс:		Нийт	Үүнээс:	
		Энгийн	Аюултай		Энгийн	Аюултай
<b>НИЙТ</b>	<b>1 104.7</b>	<b>881.7</b>	<b>223.0</b>	<b>1 202.1</b>	<b>916.2</b>	<b>285.9</b>
Хөдөө аж ахуй	37.0	37.0	-	38.4	38.4	-
Уул уурхай, олборлолт	132.4	42.2	90.1	129.4	43.9	85.6
Боловсруулах үйлдвэрлэл	152.9	152.3	0.6	158.5	158.2	0.3
Цахилгаан, дулаан, усан хангамж	269.9	145.3	124.6	336.9	151.0	185.9
Барилга	168.7	168.6	0.0	175.2	175.2	0.0
Худалдаа, үйлчилгээ	75.4	75.4	-	78.3	78.3	-
Төрийн удирдлага	59.1	59.1	-	61.4	61.4	-
Боловсрол	45.2	45.1	0.1	46.9	46.9	0.0

Эрүүл мэнд	35.7	30.2	5.5	43.9	31.4	12.5
Бусад	128.6	126.5	2.1	133.0	131.5	1.6

#### 2.1.4. ДАХИН АШИГЛАСАН, БОЛОВСРУУЛСАН ХОГ ХАЯГДАЛ

Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор цуглуулдаг. Хог хаягдлын тодорхой хэсэг нь дахин ашиглагдаж, дахин боловсруулагддаг.

Хог хаягдлыг өмнө нь ашиглаж байсан зориулалтаар эргүүлэн хэрэглээнд оруулж байвал дахин ашиглаж байна, харин хог хаягдлыг ашиглан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дахин боловсруулж байна гэж үзнэ.

Дахин ашиглах гэдэг нь тухайн зүйлийг анхны зориулалтаар нь эсвэл өөр зорилгоор ашиглах үйлдлийг хэлнэ. Энэ процесс нь дахин боловсруулахаас өөр бөгөөд дахин боловсруулах гэдэг нь хуучин зүйлийг задалж шинэ зүйл хийх түүхий эдийг гаргадаг. Дахин ашиглах нь өмнө хэрэглэж байсан зүйлийг ашиглах бөгөөд дахин боловсруулахгүй байх нь цаг хугацаа, эрчим хүч хэмнэхэд ашигтай.

Энэ дансанд “Хог хаягдлын дахин ашиглалт, боловсруулалтын жилийн мэдээ (БОХ 6.3)” маягтаар цуглуулсан мэдээллийг ашиглалаа.

#### ХҮСНЭГТ 7. ДАХИН АШИГЛАСАН, БОЛОВСРУУЛСАН ХОГ ХАЯГДАЛ, төрөл, мянган тонноор

Хог хаягдал, төрлөөр	2019	2020	2021	2022
<b>Нийт</b>	<b>250.6</b>	<b>272.9</b>	<b>186.8</b>	<b>73.4</b>
Цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал	74.3	65.8	42.7	2.2
Шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал	17.6	27.6	19.0	1.5
Хаягдал төмөр	62.6	52.9	18.1	8.1
Хуванцар бүтээгдэхүүний хаягдал	28.2	41.4	54.8	3.7
Барилгын хог хаягдал	9.7	12.3	9.0	1.5
Хүнсний бүтээгдэхүүний хаягдал	3.1	13.4	12.4	2.5
Цахилгаан барааны хаягдал	0.1	0.2	0.9	0.1
Автомашинны эд анги	1.1	18.2	4.6	1.2
Бусад хог хаягдал	53.9	41.2	25.2	52.5

Манай улсын хувьд хог хаягдлын дахин ашиглалт, боловсруулалтын түвшин харьцангуй доогуур байна. Дахин ашигласан, боловсруулсан хог хаягдлын хэмжээ 2020 онд 272.9 мянган тонн, 2021 онд 186.8 мянган тонн байсан бол 2022 онд 73.4 мянган тонн болж 2021 онтой харьцуулахад 60.7 хувиар буурчээ.

2022 оны байдлаар дахин ашиглах, боловсруулахаар цуглуулсан хог хаягдлын бүтцийг хог хаягдлын төрлөөр авч үзвэл хаягдал төмөр 11.0 хувь, хуванцар бүтээгдэхүүний хаягдал 5.1 хувь, хүнсний бүтээгдэхүүний хаягдал 3.4 хувь, цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал 3.0 хувь, барилгын хог хаягдал болон шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал 2.1 хувь, автомашинны эд ангийн хог хаягдал 1.6 хувь, бусад хог хаягдал 71.5 хувийг тус тус эзэлж байна.

#### 2.2. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ НИЙТ АШИГЛАЛТ

Хатуу хог хаягдлын нийт ашиглалт нь эдийн засагт бий болсон хог хаягдлын устгалт зайлуулалт, бусад салбарын ашиглалт, хог хаягдлын экспортоос бүрдэнэ.

Хатуу хог хаягдлын нийт ашиглалтын бүтцийг 2022 оны байдлаар авч үзвэл, цуглуулсан нийт хог хаягдлын 2064.8 мянган тонн буюу 72.2 хувийг ландфиллд булж, 240.3 мянган тонн буюу 8.4 хувийг шатааж, 334.6 мянган тонн буюу 11.7 хувийг байгальд шууд хаясан байна. Харин 2.7 мянган тонн хог хаягдлыг экспортод гаргажээ.



## ХҮСНЭГТ 8. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ НИЙТ АШИГЛАЛТ, мянган тонноор

	Хог хаягдлын устгалт	Үүнээс:				Бусад салбарын завсрын хэрэглээнд	Хатуу хог хаягдлын экспорт	НИЙТ АШИГЛАЛТ
		Ландфилл	Шатаах	Бусад	Байгаль орчинд хаягдал			
2019	2 928.4	2 328.0	256.5	0.2	343.7	250.6	2.5	<b>3 181.5</b>
2020	2 730.5	2 163.6	252.1	2.7	312.1	246.3	0.5	<b>2 977.3</b>
2021	2 581.0	2 009.4	240.9	0.0	330.6	232.5	0.6	<b>2 814.2</b>
2022	2 639.6	2 064.8	240.3	0.0	334.6	216.4	2.7	<b>2 858.7</b>

Дансны үр дүнгээс харахад манай улсад нийт хог хаягдлын ихэнхийг хогийн төвлөрсөн цэгт булшилж устгаж байна. Цаашид нөөцийг хэмнэх, байгальд бий болох дарамтыг бууруулахын тулд хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

## ГУРАВ. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хог хаягдлыг бууруулах, сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх зэрэг үндэсний бодлого, холбогдох хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх зэрэгт энэ дансны үр дүнг ашиглана. Мөн хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах үйлдвэржилтийн бодлого боловсруулах суурь мэдээлэл болно.

### 3.1. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНААС ТООЦСОН ТХЗ-ЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хатуу хог хаягдлын дансыг байгуулснаар Тогтвортой хөгжлийн зорилго-2030-ийн 11.6, 12.4, 12.5 зорилтыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд (11.6.1, 12.4.2, 12.5.1)-ийг тооцох боломж бүрдэж байна.



- [ТХЗ Зорилт 11.6](#) 2030 он гэхэд агаарын чанар, хотын болон хог хаягдлын менежментийн асуудалд онцгой анхаарлаа хандуулах замаар хотуудын нэг хүнд ногдох байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах.
- [Шалгуур үзүүлэлт 11.6.1](#) Хот суурин газарт бий болсон хатуу хог хаягдлаас эцсийн боловсруулалт хийгдсэн хатуу хог хаягдлын эзлэх хувь.



- [ТХЗ Зорилт 12.4](#) 2020 он гэхэд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын баримт бичигт нийцүүлэн химийн бодис болон бүх төрлийн хог хаягдлыг амьдралынх нь мөчлөгийн хугацаанд байгаль орчинд ээлтэй байдлаар зохицуулах.
- [Шалгуур үзүүлэлт 12.4.2](#) Цуглуулсан нийт аюултай хог хаягдалд эцсийн боловсруулалт хийсэн аюултай хог хаягдлын эзлэх хувь.



- [ТХЗ Зорилт 12.5](#) 2030 он гэхэд хог хаягдлаас сэргийлэх, түүнийг бууруулах дахин боловсруулах, дахин хэрэглэх замаар хог хаягдал бий болгож буй хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулах.
- [Шалгуур үзүүлэлт 12.5.1](#) Хог хаягдлын дахин боловсруулалтын түвшин.

Хатуу хог хаягдлын эцсийн боловсруулалт гэдэгт ландфиллд булшлах, шатаах, бусад аргаар устгах үйл ажиллагааг хамруулна.

Хог хаягдлын дахин боловсруулалтад хог хаягдлыг боловсруулж шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хог хаягдлын дахин ашиглалтыг хамруулна.



## ХҮСНЭГТ 9. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ДАНСНААС ТООЦСОН ТХЗ-ЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019	2020	2021	2022
11.6.1 Хот суурин газарт бий болсон хатуу хог хаягдлаас эцсийн боловсруулалт хийгдсэн хатуу хог хаягдлын эзлэх хувь	хувь	81.2	81.2	80.0	80.6
12.4.2 Нийт аюултай хог хаягдалд эцсийн боловсруулалт хийсэн аюултай хог хаягдлын эзлэх хувь	хувь	95.8	98.8	97.4	98.1
12.5.1 Хог хаягдлын дахин боловсруулалтын түвшин	хувь	7.9	8.3	8.3	7.6

Манай улсын хувьд цуглуулсан нийт хог хаягдлын ихэнхийг төвлөрсөн хогийн цэгт аваачиж устгаж байна. Харин хог хаягдлыг дахин боловсруулж, ашиглаж байгаа түвшин маш доогуур байна. Нийт хог хаягдлын 10 хүрэхгүй хувийг дахин боловсруулж байна.

### ДҮГНЭЛТ

Хог хаягдал нь манай улсын төдийгүй далхий нийтийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Дэлхийн банкнаас эрхлэн гаргасан "What a waste 2.0: A Global Snapshot of Solid Waste Management to 2050" тайланд дэлхий дээр жилд 2.0 тэрбум тонн хог хаягдал бий болдог бөгөөд 2050 он гэхэд 3.4 тэрбум тонн хог хаягдал болно гэж дурдсан байна.

Хатуу хог хаягдлын дансыг 2022 оны гүйцэтгэлээр байгуулж, үр дүнг танилцуулж байна. Дансны үр дүнгээс үзвэл:

- Хатуу хог хаягдлын нийт хэмжээ 2022 онд 2858.7 мянган тонн болж, 2021 оноос 44.5 мянган тонноор буюу 1.6 хувиар өссөн байна.
- Нийт хатуу хог хаягдлын 42.0 хувийг эдийн засгийн салбарууд, 55.3 хувийг өрх үүсгэж байгаа бол зөвхөн 2.6 хувийг дахин ашиглаж, боловсруулахаар цуглуулж байна.
- Нийт хатуу хог хаягдлын дансны нөөцөд хог хаягдлын импорт маш бага буюу 0.1 хувийг эзэлж байна. Хатуу хог хаягдлын импортын ихэнхийг хаягдал даавуу эзэлж байна.
- Нийт хог хаягдалд энгийн хог хаягдал 90.0 хувь, аюултай хог хаягдал 10.0 хувийг эзэлж байна.
- Нийт хатуу хог хаягдлын 72.2 хувийг ландфиллд булж, 8.4 хувийг шатааж устгасан бол 11.7 хувийг байгальд шууд хаясан байна.
- Нийт 2.7 мянган тонн хог хаягдлыг экспортод гаргажээ. Хог хаягдлын экспортын ихэнхийг хуванцар бүтээгдэхүүний хог хаягдал болон хаягдал төмөр эзэлж байна.

Хатуу хог хаягдлын дансыг сайжруулахад цаашид дараах асуудалд анхаарах шаардлагатай байна. Хатуу хог хаягдлын дансыг байгуулахдаа БОАЖЯ-ны захиргааны мэдээллийг ашигласан. Захиргааны мэдээллээр цуглуулж байгаа үзүүлэлтийн хувьд ерөнхийдөө данс байгуулах шаардлагыг хангаж байгаа боловч тоон мэдээллийн чанар төдийлөн хангалтгүй байна.

- Хатуу хог хаягдлын дансыг чанартай боловсруулахын тулд тусгайлсан судалгааг тодорхой давтамжтай явуулж, хог хаягдлын бүтэц, эх үүсвэрийг нарийвчлан тооцох,
- Хог хаягдлын мэдээ, бүртгэлийг үнэн зөв хөтлөх,
- Хатуу хог хаягдлын дансыг байгуулахдаа холбогдох мэргэжлийн байгууллага, энэ чиглэлээр судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах,
- Хатуу хог хаягдлын дансны үр дүнг бодлого боловсруулах, шийдвэр гаргалтад ашиглах байдлыг өргөжүүлэх шаардлагатай байна.

# ХАВСРАЛТ ХҮСНЭГТ



Дээрх QR кодыг уншуулж, эсхүл **ЭНД**  
дарж хавсралт хүснэгтийг татаж авна уу

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ҮСХ, Хатуу хог хаягдлын дансыг байгуулах аргачлал, 2021 он  
SEEA – Central framework, 2012  
Байгаль орчин-эдийн засгийн дансны систем - Ерөнхий хүрээ, 2012  
Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, 2022 он  
БОАЖЯ-ны Байгаль орчны мэдээллийн сан, [www.eic.mn](http://www.eic.mn)  
Нийслэлийн захирагчийн ажлын албаны хог хаягдлын мэдээлэл  
Элемент ХХК, Элемент медикал ХХК-ийн тоо мэдээлэл  
Хог хаягдлын тухай хууль  
Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын бүтцийн судалгаа, 2019 он  
ТЕГ-ын мэдээллийн бааз, хог хаягдлын хураамжийн мэдээлэл  
ГЕГ-ын мэдээллийн бааз, хог хаягдлын экспорт, импортын мэдээлэл  
<http://www.1212.mn/>